



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠢᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/301

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төвийн II бүсэд зөвшөөрөлгүй сунгасан хашаа, амбаар, чингэлэг, авто гражийн доорх газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Есөнбулаг сумын Засаг дарга)

Гишүүдэд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

(Цагдаагийн газрын дарга)

(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, аймгийн Ерөнхий архитектор)

(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын хяналтын улсын байцаагч)

2.


(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын
Захирагчийн ажлын алба)

(Есөнбулаг сумын Газрын даамал)

(Оргил, Харзат, Түмэн, Жаргалант, Жинст,
Баяншанд, Баянхайрхан, Индэрт багуудын Засаг
дарга)

Нарийн бичгийн дарга: (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын
Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн)

2.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж,
хэрэгжилтийн явц, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ